



71

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1165

Хуурч

Г Цэрэг спортын "Дөл" тэмцээн зохион  
байгуулах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Сангийн сайдын 2021 оны 61 тоот тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэрэг спортын Сэлэнгэ бүсийн "Дөл" тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсугай.

2.Цэрэг спортын Сэлэнгэ бүсийн "Дөл" тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч – Цагааннуур сумын ЗДТГ-ын дарга – Д.Алтанзориг

Гишүүд – Зүүнбүрэн сумын ЗДТГ-ын дарга – Д.Гантулга

Түшиг сумын ЗДТГ-ын дарга – Б.Уранчимэг

Цагааннуур сумын ИТХ-ын төлөөлөгч – Б.Баярмөнх

Хуурч 2 дугаар багийн засаг дарга – Н.Батбаяр

Нийгмийн бодлогын мэргэжилтэн – Б.Отгонцэцэг

Соёлын төвийн эрхлэгч – З.Бэхбат

3.Цэрэг спортын "Дөл" тэмцээнд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

4.Цэрэг спортын "Дөл" тэмцээний шагналын зардал 400,0 мян/төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Цэрэг спортын "Дөл" тэмцээнийг удирдамжийн дагуу осол гэмтэлгүй, өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.



Ц.БАЯНБААТАР